



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Мэдээллийн схем баталж, мэдээлэл
дамжуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа төрийн байгууллага, төрийн өмчит компани, улсын төсөвт үйлдвэрийн газраас “Гамшиг, осол, зөрчил, саатлыг мэдээлэх схем”-ийг хавсралтаар баталсугай.

2. Зам, тээврийн салбарт осол, зөрчил, техникийн саатал, гэмтэл гарсан тохиолдолд цаг алдалгүй хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор дор дурдсан мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагуудад нэн даруй мэдэгдэж, шуурхай дамжуулж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

2.1 Улс, хот хоорондын зорчигч, ачаа тээвэр, нийтийн тээврийн үйл ажиллагаанд гарч байгаа зам тээврийн осол, зөрчил, байгалийн гамшиг, цаг агаарын хүндрэл, бэрхшээл болон гол мөрөн, нуурын ус бүрэн хөлдөөгүй байх үед хийсэн тээвэрлэлт, батлагдсан гармаас бусад газраар гарч хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан, хохирол учирч болзошгүй тохиолдолд мэдээллийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/, “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар /Д.Дэлгэрнаран/-т;

2.2 Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой сүйрэл, осол, гологдол гарсан, хөдлөх бүрэлдэхүүний техникийн гэмтэл болон байгалийн гамшиг, цаг агаарын хүндрэл, бэрхшээлийн улмаас галт тэрэгний хөдөлгөөн саатсан тохиолдолд мэдээллийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг /Д.Жигжиднямаа/, “Монголын төмөр зам” төрийн өмчит компани /Б.Цэнгэл/, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /Т.Ариунбаатар/-т;

2.3 Нислэг-техникийн гэмтэл, осол, нислэг, үйлчилгээний дүрэм журам, хууль тогтоомжид заасан зөрчил гарсан, байгалийн гамшиг, цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлын улмаас агаарын хөлөг түр болон урт хугацаагаар саатсан, эрх бүхий байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хариуцлагагүй үйлдлээс шалтгаалан олон улсын нислэг хойшилсон тохиолдолд мэдээллийг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/, Монголын иргэний агаарын тээвэр” төрийн

өмчит хувьцаат компани /Д.Баттөр/, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-нд;

2.4 Байгалийн гамшиг, цаг агаарын хүндрэл бэрхшээлийн болон бусад шалтгааны улмаас улсын болон орон нутгийн чанартай авто зам хаагдах, зам засвар, замын барилга угсралтын ажил зогсох, зам, гүүрийн эвдрэл гарсан тохиолдолд мэдээллийг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчид үйлдвэрийн газар /Р.Буд/-т;

2.5 Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц болон усан замын тээвэрлэлттэй холбоотой осол, зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэс /Д.Жавхлан/, Далайн захиргаа /С.Түвшинтөр/-нд;


3. Гарсан гамшиг, осол, зөрчил техникийн саатал, гэмтлийн шалтгааныг тогтоож, үүссэн нөхцөл байдалтай уялдуулан яаралтай арга хэмжээ авч, шийдвэрлэснээс хойш ажлын 5 өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай зөвлөгөөнд тухайн асуудлын талаар илтгэх хуудсаар танилцуулж байхыг тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа төрийн байгууллага, төрийн өмчит компани, улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

4. Осол, зөрчлийн талаарх мэдээллийг дамжуулах үүргээ биелүүлээгүй этгээдэд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Харьяа төрийн байгууллага, төрийн өмчит компани, улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга захирал нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /Л.Халтар/-д даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн “Осол, зөрчлийн талаарх мэдээллийг шуурхай дамжуулж ажиллах тухай” 30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Я.СОДБААТАР

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
10 дугаар сарын 29-ны өдрийн
23 дугаар тушаалын хавсралт

ГАМШИГ, ОСОЛ, ЗӨРЧИЛ, СААТЛЫГ МЭДЭЭЛЭХ СХЕМ

